

**Уурхайн талбайн хилийг тогтоож, байнгын шав тэмдэг тавих
ажлын даалгавар**

Төслийн товч танилцуулга:

“Хашаат Овоот Даваат” нэртэй MV-022859 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь засаг захиргааны хувьд Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн нутагт оршдог. Улаанбаатар хотоос баруун хойшоо 240км, Заамар сумын төвөөс хойшоо 25км-т, байр зүйн зургийн M-48-137 нэрэлбэрт оршино. Нийт 2545,27 га бүхий талбай, 44 цэгтэй болно.

Тусгай зөвшөөрөл болон уурхайн талбайн хилийг тогтоож, шав тэмдэг тавихдаа дараах техникийн шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Тусгай зөвшөөрөл болон уурхайн талбайн хилийн булангийн цэгийн солбицолуудыг газар дээр байгуулах хэмжилтийг Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан солбицолын WGS систем, UTM тусгагт хийнэ.
2. Тусгай зөвшөөрөл болон уурхайн талбайн хилийн булангийн цэгийн солбицолуудыг газар дээр хийсэн хэмжилтийн үр дүнгээр тогтоож, байнгын шав тэмдэг суулгаж баталгаажуулна.
3. Тусгай зөвшөөрөл болон уурхайн талбайн хилийн булангийн цэгийн солбицолуудыг газар дээр байгуулах хэмжилтийн нарийвчлал нь 1:1000-ны масштабтай газрын зургийн нарийвчлалтай байна.
4. Шав тэмдгийг 1.5 м урттай 50 мм-ээс багагүй хөндлөн огтлолтой төмөр материалаар хийж, газар дээр байрлах цэгийн толгой хэсэгт чагтан тэмдэглэгээ хийсэн байна.
5. Шав тэмдгийг бэлтгэх, газарт суулгах, гаднах тэмдэглээс хийхдээ Геодезийн байнгын цэг, тэмдэгт байгуулах ажил /БД 11-104-06/-ийг дагаж мөрдөнө.
6. Шав тэмдгийн дээд хэсэгт тусгай зөвшөөрөл, булангийн цэгийн дугаарыг ган хасуураар арилгахгүйгээр тод бичнэ.
7. Шав тэмдгийн солбицол, байршлын бүдүүвч болон фото зургийг тайланд хавсаргана. Шав тэмдгийн жагсаалтыг батлагдсан загварын дагуу үйлдэнэ.
8. Шав тэмдгийг газарт бэхэлж, батлагдсан загварын дагуу акт үйлдэнэ.
9. Тусгай зөвшөөрөл болон уурхайн талбайн хилийн булангийн цэгийн солбицолуудыг тогтоолгож, байнгын шав тэмдэг тавьсан актыг АМГТГазарт хүргүүлж, баталгаажуулна.

Үндэслэл:

- Геодези зураг зүйн тухай хууль;
- Монгол Улсын Засгийн Газрын 25 дугаар тогтоол;
- Геодезийн байнгын цэг, тэмдэгт байгуулах ажил /БД 11-104-06/
- Ашигт малтмалын тухай хууль

Тайлан гаргах хуваарь:

Гэрээ байгуулагдсанаас хойш 60 хоногийн дотор боловсруулж, Захиалагчид хүлээлгэн өгнө.